МЭДЭЭ · 2025 оны 1-р сарын 29

2024 ОНД - ПРОКУРОР ТӨР, НИЙТИЙН АШИГ СОНИРХОЛД УЧИРСАН 33.7 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЖЭЭ



Прокурорын байгууллага 2024 онд төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийн хүрээнд 64 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1973 иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байна. Тухайлбал,

- Төрийн албан хаагчийг хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсны улмаас төрд учруулсан 206.6 сая төгрөг,

- Гэмт хэрэг, зөрчлийн улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан 330.3 сая төгрөг,

- Эрүүл мэндийн даатгалын санд учирсан 603.4 сая төгрөг,

- Засгийн газрын тусгай сангуудаас олгосон 2.5 тэрбум төгрөг,

- Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөртэй холбоотой 28.4 тэрбум төгрөгийн хохирол, төлбөрийг гаргуулах иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байна.

Үүнээс 1337 иргэний хэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, төр,

нийтийн ашиг сонирхолд учирсан 33.7 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллалаа.

Тухайлбал, Иргэний нисэхийн ерөнхий газрын хүсэлтээр “гэрээний үүргийн гүйцэтгэл”-тэй холбоотой 411.1 сая төгрөг, Нийгмийн даатгалын газрын хүсэлтээр “нийгмийн даатгалын шимтгэл, алданги гаргуулах”-тай холбоотой 26.6 тэрбум төгрөгийг гаргуулсан байна.

Түүнчлэн Төрийн байгууллагын хүсэлтээр “ажил гүйцэтгэх гэрээ”-тэй холбоотой 9.1 тэрбум төгрөг, “Түрээсийн гэрээ”-тэй холбоотой 8.4 тэрбум төгрөг гаргуулах иргэний хэрэгт прокурор төрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдээр оролцож төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалан ажиллаж байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1070